

Технологийг хариуцлагатай ашиглах

1-р хэсэг. Технологид цагаа ухаалгаар зарцуулах нь

Сургаал ба Гэрээнд Их Эзэн “санаа сэтгэлээ бүрэн зориулах” болон “цагаа дэмий үрэх” гэсэн нэр томъёог ашигладаг.

- Эдгээр нэр томъёо ямар утгатай гэж та бодож байна вэ?

Сургаал ба Гэрээ 58:27–28; 60:13; 68:31; 75:3 зэрэг судруудыг уншаад, Их Эзэн санаа сэтгэлээ бүрэн зориулах, цагаа дэмий үрэх талаар юу зааж байгаа талаар тунгаан бод.

- Та Их Эзэний заасан зүйлийг хэрхэн хураангуйлан дүгнэх вэ?

(Хэд хэдэн үнэнээс гадна та дараах үнэнийг тодорхойлж болох юм. Их Эзэн биднийг цагаа дэмий үрэхгүй, сайн сайхны төлөө санаа сэтгэлээ бүрэн зориулаасай гэж хүсдэг.)

- Технологид цагаа дэмий үрж байгаагаа бид хэрхэн мэдэж болох вэ?

Дараах мэдэгдлийг судлаад, технологийг ухаалгаар ашиглах талаарх ойлголтыг олж мэд.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн заасан.



Амьдралын туршлага маруухан, төөрөлдсөн [хувь хүн] нь байж боломгүй их цагийг видео тоглоом тоглоход, онлайнгаар харьцахад эсвэл “юмсыг байгаагаар нь” хүлээн авах боломжгүй болгодог дижитал

зүйлсэд зарцуулдаг байж магад. Эхэндээ өдөр тутмын ажлын ачааллаасаа амсхийн хэдхэн минутыг үүнд зарцуулж байгаа нь харьцангуй гэм хоргүй мэт санагдаж магадгүй. Гэвч хүн хоорондын харилцааны ур чадвараа хөгжүүлэх, сайжруулах чухал боломжуудаа алдсан байдаг. . . . Алгуурхнаар, гэмгүй мэт санагдах зугаа цэнгэл хор хөнөөлтэй боолчлол болсон байх нь бий. (David A. Bednar, “Things as They Really Are,” *Ensign*, June 2010, 21)

- Хүмүүс технологид цаг заваа дэмий үрж байгаагаа ямар ямар шалтгаан тоочин зөвтгөдөг вэ?
- Технологид цагаа дэмий үрэхээс зайлсхийхэд юу танд тусалдаг вэ?
- Та технологийг ухаалгаар ашигладаг болохын тулд Их Эзэнийг хэрхэн үүнд оролцуулж болох вэ?

2-р хэсэг. Сайн медиа хэрэгслийг сонгох

- Та ямар медиа хэрэгслийг тогтмол сонгодог вэ?
- Медиа хэрэгслийг сонгохтой холбоотой туршлагаасаа Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой илүү ойртоход туслах юуг та сурч мэдсэн бэ?

Сургаал ба Гэрээ 50:23–24; Итгэлийн тунхаг 1:13; Моронай 7:12–17-г тус тус уншаад, юу нь сайн, юу нь муу болохыг тодорхойлоход бидэнд туслах үнэнийг хайж ол.

- Та эдгээр шүлгээс ямар ямар үнэнийг олж мэдсэн бэ?

(Хэдэн үнэнээс гадна та дараах үнэнийг тодорхойлсон байж болно. Сайныг үйлдэхэд ятгадаг, сэнхрүүлдэг тэр зүйл Бурханаас ирдэг.)

- Ашиглах медиа хэрэгслээ сонгохдоо энэ үнэнд тулгуурлах нь хэрхэн танд туслах вэ?

Ахлагч Дэвид А.Бэднар ашигладаг медиа хэрэгслийнхээ талаар дараах асуултыг өөрсдөөсөө асуухыг урьжээ.



Олон янзын техник технологи, мэдээллийн хэрэгслийг ашиглах нь таны амьдралд Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг урьдаг уу эсвэл үүнд саад болдог уу? (David A. Bednar, “Things as They Really Are,” *Ensign*, June 2010, 23)

- Та медиа хэрэгслийг сонгохдоо Ариун Сүнсийг хэрхэн урьж болох вэ?
- Аврагчаас холдуулж болох медиа хэрэгслүүдээс зайлсхийхэд юу танд тусалж болох вэ?